

Огноо 2023 оны 5-р сарын 08

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНД

*УИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт,  
өөрчлөлтийн төсөлд санал өгөх тухай*

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ нь 2008 онд үүсгэн байгуулагдсан, сонгуулийн үйл явцын ил тод байдлыг сайжруулахад иргэний нийгмийн хяналт, оролцоог хангах зорилготой төрийн бус байгууллагуудын сүлжээ юм. Тус сүлжээний гишүүн байгууллагууд сонгуулийн ажиглалт, зардлын тайлан, сонгогчдын нэрийн жагсаалт, нийгмийн сүлжээн дэх сонгуулийн сурталчилгаа зэрэг асуудлаар хяналт шинжилгээг хуулийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн туршлагатай. 2023 оны 4-р сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-д сүлжээний гишүүн байгууллагуудын байр суурийг нэгтгэн дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна.

Хуулийн төсөлд гадаадад байгаа иргэдээс санал авах, урьдчилсан санал хураалт болон нэрийн жагсаалтад хяналт тавих зохицуулалтыг сайжруулан хуульчилж буйг иргэний нийгмийн зүгээс сайшаан хүлээн авч байна. Үүний сацуу хуулийн төслийг боловсронгуй болгоход дараах асуудлуудыг анхаарах шаардлагатайг онцолж байна.

### НЭГ. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТОЙРОГ БАЙГУУЛАХ ТУХАЙ:

#### САНАЛ:

- Сонгуулийн тойрог нь сонгуулийн тогтолцооны салшгүй чухал элемент байдаг учир тойргийг хэрхэн байгуулах асуудлыг Улсын Их Хуралд суудалтай болон суудалгүй нам, эвсэл, олон нийт, судлаачидтай зөвшилцөн, үүсч болох давуу болон сул талыг сайтар тооцоолсны үндсэн дээр анхнаас нь тодорхой ойлгомжтой тусгах;
- Пропорциональ/хувь тэнцүүлэх тогтолцоонд “улс нэг тойрог” байх туршлага олон улсад түгээмэл бөгөөд энэ нь улс төрийн намуудын бодлого үйл ажиллагааг дэмжсэн сонголт хийхэд иргэдэд илүү дөхөм байдгийг анхаарах;
- Сонгогч нэг бүрийн санал сонгуулийн эцсийн үр дүнд ижил тэнцүү нөлөөлөл үзүүлэх баталгаа болох шударга сонгуулийн “нэг сонгогч-нэг санал-нэг ижил үнэ цэн” зарчмыг харгалзан олонхын тойргуудад “мандатад ногдох сонгогчдын тооны зөрүү 15 хувиас илүүгүй” байх зарчмыг тойрог байгуулах үндсэн нөхцөлд тусгаж нэмэх;
- Хуулийн төслийн 74.3.2-т заасан пропорциональ суудал хуваарилах тооцооллыг хийхэд сонгогчийн санал өгөөгүй нам, эвсэлд сонгогчдын саналыг нэмж тооцох нь сонгогчийн саналаа чөлөөтэй, шууд гаргах эрхийг зөрчих тул хасах



## 1.1

Хуулийн төслийн 4.3.1-4.3.2, 30.1, 30.5-д сонгуулийн тойрог болон нам, эвслийн нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас УИХ-ын гишүүдийг сонгох “сонгуулийн холимог тогтолцооны хосолсон/параллель хувилбар”-ыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонгуулийн тогтолцоог тодорхойлох нэг чухал хүчин зүйл бол сонгуулийн тойрог байдаг. Төсөлд сонгуулийн тойргуудыг ямар зарчимд үндэслэн байгуулах тухай асуудал бүрхэг тусжээ. Жишээлбэл, хуулийн төслийн 11.4-т “пропорциональ/хувь тэнцүүлэх” зарчмаар сонгогдох нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтыг “Монгол Улсын урт хугацааны бодлогод нийцүүлэн хувааж болно” гэсэн нь бүсчилсэн байдлаар тойргууд байгуулах санаа агуулж буй агаад ийнхүү бүрхэг тусгасан нь хэрэгжүүлэх явцад маргаан дагуулж болзошгүй байна.

## 1.2

Мөн мажоритари/олонхын тогтолцооны тойргуудыг байгуулахад мандатад ногдох сонгогчдын тоо хэт зөрүүтэй байгаа асуудлыг шийдвэрлээгүй орхигдуулжээ. Өмнөх сонгуулиар энэ зөрүү 50 хувь хүрснийг дотоодын болон олон улсын ажиглагчид шүүмжилсэн байдаг. Иймд сонгуулийн тойрог байгуулахдаа тухайн тойргийн нэг мандатад ногдох сонгогчийн тоог аль болох зөрүүгүй байлгах, нэг мандатад ногдох сонгогчийн тооны зөрүүг олон улсын сайн туршлагын дагуу 15 хувиас ихгүй байлгах тухай хуулийн төсөлд тодорхой тусгах нь зүйтэй.

## 1.3

Хуулийн төслийн 74.3.2-т заасан пропорциональ суудал хуваарилах тооцооллыг хийхэд нийт сонгогчийн 3-аас доош хувь аваагүй нам болон 5-аас дээш хувийн санал аваагүй эвслийн сонгогчийн саналыг шаардлагыг хангасан бусад нам, эвсэлд хуваан олгохоор зохицуулжээ. Энэ нь сонгогч өөрийн итгэл үнэмшилд үндэслэн буюу **чөлөөтэй сонгох** эрхээ хэрэгжүүлэн өгсөн саналыг тухайн сонгогчийн дэмжээгүй нам, эвсэлд шилжүүлэн тооцож **шууд сонгуулийн зарчмыг** мөн давхар **зөрчих** тул хасах нь зүйтэй.



## ХОЁР. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА, САНАЛ ӨГӨХ ТУХАЙ:

### САНАЛ:

- Сонгуулийн сурталчилгааны хугацааг богиносгохгүй байх;
- Сонгогч хувь тэнцүүлэх/пропорциональ зарчмаар нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас сонголт хийхэд нам, эвслийн зүгээс жагсаалтаа ил тод танилцуулах хугацааг тодорхой заах, жагсаалтыг эрэмбийг тогтоох процесст ардчилсан зарчим баримтлахыг хуульчлах, саналын хуудсанд сонгогч намд санал өгөх байдлаар зохицуулах;
- Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдээс гадна бусад гуравдагч этгээд сурталчилгаа санхүүжүүлж буй нөхцөлд хэрхэн хянаж зохицуулах талаар тодорхой тусгах. Энэ үзэгдэл ялангуяа нийгмийн сүлжээнд ажиглагддаг болохыг анхаарах;.
- Сонгуулийн зардлын хуулиар зөвшөөрсөн нэг эх үүсвэр “нэр дэвшигч”-ийн өөрийн хөрөнгөд олон улсын жишиг, сайн туршлагын дагуу хязгаар тогтоох замаар сонгуулийн тэгш гарааны нөхцөлийг бүрдүүлэх;
- ХХЗХ, ШӨХТГ-ийн хяналт, тайлагнал, ил тод байдлыг хангах журмыг батлан хэрэгжүүлэх, мэдээлэл ил тод байх, олон нийтийн хяналтад байх тухай тусгайлсан заалт тусгах;
- ХХЗХ, ШӨХТГ-аас ҮАГ-т холбогдох мэдээлэл, дүгнэлтийг хүргүүлж, зардлын тайланг бодит гаргаж буй эсэх хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хуульчлан заах.

## 2.1

Хуулийн төслийн 32.12-т сонгуулийн сурталчилгаа 18 хоног үргэлжлэхээр буюу өмнөхөөс 4 өдрөөр богино байхаар тусгажээ. Энэ хугацаа нь мэдээлэл хүлээн авч, түүнд үндэслэн сонголт хийхэд хангалттай бус байна. Ялангуяа, гадаад улсад байгаа сонгогчдын хувьд хугацаа хангалтгүй байхаар байна. Тодруулбал, гадаад улсад санал хураалтыг 4 өдөр зохион байгуулах бөгөөд энэ нь саналын хуудсыг Монгол Улсад ирүүлэх бэлтгэл хугацааг оруулбал 10 орчим өдөрт сонгуулийн сурталчилгааны мэдээллийг хүлээн авах бололцоотой байна.



## 2.2

Хуулийн төслийн 59.4-т “саналын хуудас нь... нам, эвсэл тэдгээрээс нэр жагсаалтаар нэр зохицуулалт нь ихээхэн төөрөгдөл үүсгэж хүчингүй саналын тоо эрс нэмэгдсэн муу туршлага байдаг. Үүнээс зайлсхийх нь зүйтэй.

## 2.3

Хуулийн төслийн 47.12-т цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулсан тохиолдолд зарцуулах зардлын дээд хэмжээ нь нийт сонгуулийн зардлын 15 хувиас хэтрэхгүй байх зохицуулалт тусгажээ. Сонгуульд оролцож буй этгээдээс бусад гуравдагч этгээд цахим орчинд сонгуульд өрсөлдөгч аль нэг талыг дэмжиж буюу эсэргүүцэж зардал гаргах нь түгээмэл ажиглагддаг ба үүнийг тодорхой зохицуулахгүй аваас 15 хувийн хязгаар тавих нь ач холбогдол багатай гэж үзэж байна. Олон улсын туршлагаар гуравдагч этгээдээс гарсан аливаа зардлыг тооцох, ил тод мэдээлэх зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Түүнчлэн сонгуульд оролцогчийн талаарх мэдээллийг илт зохион байгуулалттай, төлбөртэй тарааж буй гуравдагч этгээдийг ухуулагчаар бүртгэх асуудлыг судалж үзэх нь зүйтэй.

## 2.4

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтын 49.2 дахь заалтад сонгуулийн зардлыг “хандив, намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө байх” гэсэн гурван эх үүсвэрийг зааж өгсөн. Чинээлэг нэр дэвшигчид өөрийн хөрөнгөөс зарцуулах зардалд аливаа хязгаар тавьдаггүй нь иргэдээс хандив цуглуулж дэмжлэг олж авах сэдлийг бууруулж, гарааны тэгш бус байдлыг өдөөж буй нь шударга сонгуулийн зарчимд нийцэхгүй. Ийм учраас Канад гэх мэт бусад ардчилсан улсуудад улс төрч өөрөөс гаргаж болох хөрөнгийг хандивын дээд хязгаартай уяж хязгаар тогтоосон байдаг. Иймд сонгуульд нэр дэвшигчид ижил гараанаас гарч тэгш өрсөлдөх нөхцөлийг хангах үүднээс өөрийн хөрөнгийг зарахад баримтлах хязгаарыг тусгах нь зүйтэй.

## 2.5

Хуулийн 39 дүгээр зүйлд сонгуулийн сурталчилгааг хэвлэл мэдээллийн байгууллагаар нэвтрүүлсэн тохиолдолд тухайн хэвлэл мэдээллийн байгууллага сурталчилгаа явуулсан тайлангаа өөрөө мэдээлэхээс гадна Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар (ШӨХТГ)-т хүргүүлэхээр заасан. Мөн Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) сурталчилгаа явуулах хэвлэл мэдээллийн байгууллагуудыг бүртгэж, дундаж үнийн саналыг хүлээн авдаг. Энэхүү хуулийн зохицуулалтын хэрэгжилтэд 2020, 2021 сонгуулиар хяналт, шинжилгээ хийхэд дараах анхаарах асуудлууд байна. Үүнд:

- ХХЗХ, ШӨХТГ нь нэгдсэн журам, маягт, стандартын дагуу хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээллийг хүлээн авахгүй байна. Мөн материалыг хүлээж авсны дараа хянан үзэх хяналтын ажиллагаа явагдахгүй, хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагын хүргүүлж буй тайланг олон нийтэд мэдээлэхгүй байгаагаас гадна сурталчилгаа явуулсан тайланг дагалдаж нэр дэвшигч, нам эвсэлтэй хийсэн гэрээ зэрэг баримтуудыг хүлээн авахгүй байна.
- Сонгуулийн сурталчилгаа явуулсан тайланг хүлээн авах, хяналт тавих үйл явц нь сонгуулийн зардлын тайлангийн зохицуулалттай уялдахгүй, Үндэсний аудитын газрын хяналт тавих үйл явцад дэмжлэг үзүүлэхгүй байна.

### ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ, ТАЙЛАГНАХ, САНАЛ ӨГӨХ ТУХАЙ:

#### САНАЛ:

- Мэдээлэл хариуцагч төрийн байгууллагуудад сонгуулийн зардлын тайланг олон нийтэд ил болгох үүргийг тодорхой хуульчлах;
- Хуульд хуулийн этгээдээс авч буй хандивын хэмжээг нэмэгдүүлсэн байгааг одоогийн хуульд байгаагаар нь бууруулах;
- Сонгуулийн үйл ажиллагаанд хандив этгээдийн нэрнээс гадна хэн болохыг тодорхойлох мэдээлэл нь сонгууль ил тод, хуулийн дагуу явуулах, олон нийт хянах боломжтой байхын үндэс юм. Үүнийг Үндсэн хуулиар тодорхойлсон ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд нийтийн эрх ашгийн үүднээс ил болгох нь хүний эрхийг зөрчихгүй болохыг Хүний эрхийн үндэсний комиссоос тогтоосныг хуульд тусгах;
- Мөн зардлын тайлан хүлээн авах, тайлагнах үйл явцыг цахимжуулах, ил тод байдлыг хангахыг хуульчлан заах саналтай байна.

### 3.1

Сонгуулийн зардлыг бууруулахад чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Үүнд урт болон богино хугацаанд авч болох арга хэмжээг сайтар бодолцон хуульд тусгах нь зүйтэй юм. Богино хугацаанд, тухайлбал, холимог тогтолцоогоор сонгууль явуулдаг ХБНГУ, Япон улсуудад нэр дэвшигчдийн хэвлэмэл сурталчилгааг Сонгуулийн байгууллага нь нэгдсэн стандарттайгаар хэвлэн, иргэд нэг дороос мэдээлэл авах боломжтой байдлаар хэрэгжүүлдэг нь сонгуулийн зардлыг бууруулах ач холбогдолтой байдаг. Түүнчлэн нэр дэвшигчдийн мэдээллийг нэгдсэн самбарт байршуулах тухай саналыг сонгогчдын зүгээс тавьж ирснийг ч харгалзах нь зүйтэй. Харин урт хугацааны хувьд бодлогын мэтгэлцээн голлох сонгуулийн сурталчилгааг дэмжсэн зохицуулалтуудыг хуульд тусгах нь ач холбогдолтой болохыг анхаарна уу. Тухайлбал, Солонгос улсад Үндэсний сонгуулийн хороо нь сонгуулийн мэтгэлцээн зохион байгуулах тусгай үүрэг хүлээсэн хэлтэстэй байна. Сонгуулийн сурталчилгааны хэв маягийн өөрчлөлт нь сонгуулийг хувь хүмүүсийн хоорондын уралдаан биш бодлогын өрсөлдөөн болгоход дөхөм болоод зогсохгүй тэр хэрээр зардлыг бууруулах давхар ач холбогдолтой юм.

### 3.2

Хуулийн төслийн 54.1 болон 54.2-т иргэний хандив 10 сая хүртэл, хуулийн этгээдийн хандив 30 сая хүртэл төгрөг байж болохоор эрс нэмэгдүүлжээ. Энэхүү хандивыг нэмэгдүүлж буй үндэслэл тодорхойгүй байна. Олон улсын хандлагыг туршлагыг авч үзэхэд хуулийн этгээдийн хандивыг бууруулах, хязгаарлах чиглэлийг баримталж байна. Ийм арга хэмжээ авч чадахгүй байгаа АНУ гэх мэт улсуудад төрийн зарим бодлого шийдвэр (дайны зориулалтын галт зэвсэг иргэдэд худалдахыг хориглох гэх мэт) улс төрчдөд хандив өгдөг хувийн хэвшлийн байгууллагуудын хүчтэй лоббид чөдөрлөгдөн олон жил гацах гэх мэт сөрөг үзэгдэл гарч байна. Монгол улсын хувьд Канад, Солонгос гэх мэт ардчилсан улсуудын туршлагаар хуулийн этгээдийн хандивыг хязгаарлан улс төр дэх мөнгөний зохисгүй нөлөөг улам газар авахаас өмнө арилгах нь чухал гэж үзэж байна.

### 3.4

Зардлын тайланг бүхэлд нь **ил тод** болгох зорилгоор тус сүлжээний гишүүн Бодлогод залуусын хяналт ТББ-аас УИХ-ын 2020 болон Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулиудын зардлын тайлантай бүрэн эхээр нь танилцахад “сонгуулийн зардлын тайлан түүнд хавсаргасан материалаас сонгуулийн санхүүжилт хэрхэн бүрдсэн, ямар хүн, байгууллагаас ямар төрлийн үйлчилгээг хэдийд авсан зэрэг сонгуулийн үйл явц шударга, хуулийн дагуу өрнөсөн эсэх, санхүүжилтийг зохих ёсоор зарцуулсан эсэхэд дүгнэлт өгөхөд шаардлагатай мэдээлэл дутмаг байв. **Сонгуулийн зардлын эцсийн тайланг бүхэлд нь ил болгохыг холбогдох хууль тогтоомжид заагаагүй гэх шалтгаанаар холбогдох мэдээлэл хариуцагч төрийн байгууллагууд эцсийн тайланг гаргаж өгөхөөс татгалзаж байна.**

### 3.5

Сонгуулийн зардлыг тайлагнах тухай зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байна. Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 57-р зүйлд “Сонгуулийн зардлын тайланд орлого ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана,” “зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт зарлагын тайланг гаргана” гэж зарчмын хувьд томъёолсон боловч энэхүү заалт нь хэрэгжихгүй байна. Тухайлбал, тайлан гаргагч нь зардлын тайлангийн задаргааг дэлгэрэнгүй тусгаагүй, зардлын тайланд тусгасан мөнгөн дүнг нотлох санхүүгийн баримтууд буюу гүйцэтгэл, зарлага гаргах болсон үндэслэл болох бусад этгээдтэй хийсэн гэрээг тайланд хавсаргаагүй тохиолдол гарч байна. Иймд санхүүгийн хяналтын механизмыг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах замаар зардлын тайлагналтыг үнэн зөв, баталгаатай байдлыг хангах шаардлагатай байна.



## ДӨРӨВ. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ХОЛБООТОЙ, САНАЛ ӨГӨХ ТУХАЙ:

### САНАЛ:

#### **Сонгогчдын нэрийн жагсаалтыг дараах байдлаар байнгын болгох:**

- Монгол улсын иргэн 18 насанд хүрсэн өдөр нь шууд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгддэг байх
- Гадаадад урт болон богино хугацаагаар зорчиж байгаа иргэдийн мэдээллийн дагуу тухай бүр нэмэлт өөрчлөлт ордог байх
- Шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй болох, сэргээгдэх тохиолдол бүрт нэмэлт өөрчлөлт ордог байх
- Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хорих ял эдэлж байгаа иргэдийн мэдээллийн дагуу тухай бүр нэмэлт өөрчлөлт ордог байх

Энэ тохиолдолд “e-mongolia” цахим системд холбогдон сонгогч нэрийн жагсаалтын талаарх мэдээллээ байнга, тогтмол шалгах боломж бүрдэх бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх лавлагааг ч цахимаар авах боломж бүрдэнэ. Тиймээс сонгуулийн хууль тогтоомжийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтаа үйлдэхдээ “сонгогчдын бүртгэлийн цахим сан”-д үндэслэн хийхээр зохицуулах юм.

#### **Сонгогчдын нэрийн жагсаалтад тавих хяналтыг сайжруулахад:**

- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээд, энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн төрийн бус байгууллагын хүсэлтийн дагуу энэ хуулийн ...-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр олгоно.
- Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээд, энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн төрийн бус байгууллагын хүсэлтийн дагуу энэ хуулийн ..., ...-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулбарлан санал хураалт дууссанаас хойш 3-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр олгоно.

**Нэг сонгогч нэг санал өгөх зарчмыг хангахтай холбоотой дараах агуулгыг нэмж тусгах шаардлагатай:**





## ДӨРӨВ. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТТАЙ ХОЛБООТОЙ, САНАЛ ӨГӨХ ТУХАЙ:

- Сонгогчдын нэрийн жагсаалтын нэг л цахим систем байх
- Сонгогч саналаа өгсөн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалтын цахим системд санал өгсөн хэсэг, цагийг бүртгэх
- Сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдлийг шалгаж үзэхэд өмнө нь саналаа өгөөгүй тохиолдолд сонгогчид бүртгэлийн хуудас олгох
- Эрчим хүч тасрах, интернэтэд холбогдох боломжгүй байх тохиолдлуудад хэрхэн гар ажиллагааг хийх тусгай журмыг тусгасан байх.
- Энэ нь нэг сонгогч нэг л удаа саналаа өгөх боломжийг баталгаажуулж, давхар саналаа өгөхөөс сэргийлэх зохицуулалт болж чадна.

**Сонгогчийн нэрийн жагсаалтын “түр хасав” төлөвийг сэргээхтэй холбоотой харилцааг журмаар зохицуулахыг хуульчилж, иргэдийн хяналт тавих бололцоог бүрдүүлэх.**

### 4.1

*Сонгогчдын нэрийн жагсаалтыг байнгын болгох:* Одоогийн хуулийн зохицуулалтаар сонгууль тус бүрээр сонгогчдын нэрийн жагсаалтыг тухай бүр үйлддэг бөгөөд энэ нь сонгогчдод төвөгтэй, сонгогч нэрийн жагсаалт дахь бүртгэл, өөрчлөлтөө хянах, иргэний шилжилт хөдөлгөөнтэй уялдуулан тухай бүр шинэчлэх боломжгүй байдаг. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д зааснаар иргэний улсын бүртгэлийн цахим санг үндэслэн иргэний улсын бүртгэлийн байгууллага сонгогчийн бүртгэлийг үйлддэг бөгөөд энэ үйл явцыг тогтмол, байнгын, тухай бүр шинэчлэгддэг бүртгэлийн төрөл болгон Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах боломжтой.

### 4.2

*Сонгогчдын нэрийн жагсаалтын хяналт:* Сонгогчдын нэрийн жагсаалтын хяналтыг бодитой хийх боломж нь нэрийн жагсаалтыг үйлдэх, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, мөн саналаа өгсөн сонгогчдын мэдээллийг агуулсан нэрийн жагсаалтыг тулган шалгах, нягтлах явдал бөгөөд энэ нь урьдчилсан, явцын, сүүлийн хяналтыг багтаах шаардлагатай.

### 4.3

*Нэг сонгогч нэг санал өгөх зарчмыг хангах:* Сонгогчдын нэрийн жагсаалтын цахим сан нь нэг л байх бөгөөд одоогийнх шиг сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсэг тус бүрээр салгаж, хуваахгүйгээр нэг мэдээллийн сантай ажиллах шаардлагатай. Одоогийн сонгуулийн хууль тогтоомжоор сонгогчдын нэрийн жагсаалт нь сонгуулийн хэсэг тус бүрд хуваагдаж гардаг бөгөөд энэ тохиолдолд нэрийн жагсаалтын давхардлыг хянаж шалгах боломжгүй, сонгогч нэгээс дээш удаа саналаа өгөх боломжийг бүрдүүлэх зэрэг сул талтай байсан. Нөгөө талаас 2012 оноос хойш сонгогчдын нэрийн жагсаалтын автоматжуулсан иж бүрдлийг нэвтрүүлсэн бөгөөд Цахим хөгжлийн яамтай болсны зэрэгцээ техник болон технологийн хувьд ийм шинэчлэл хийх хангалттай нөөц, боломжтой болсон.

### 4.4

УИХ-ын 2020 оны сонгуулийн хяналт шинжилгээгээр нэрийн жагсаалтад байх “түр хасав” төлвийн бүртгэл иргэний бүртгэлтэй зөрчилдөх, давхардах, ил тод бус, сонгуулийн дараа аудит хийгддэггүй, цаасаар бүртгэгдэх буюу сэргээх үйл явц нь чирэгдэл ихтэй байсан нь сонгогчдод тодорхой бус байх алдаа дутагдлыг илрүүлсэн.